

**ТӨРИЙН БАНКНЫ ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН  
ДАНЗАНБАЛЖИРЫН ЭНХЖАРГАЛЫН  
2023 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2023 оны сүүлийн хагас жилд зарлагдсан ТУЗ-ийн болон Хорооны 10 хуралд 100 хувь дараахь байдлаар оролцлоо. Үүнд:ТУЗ-ийн 6 хурлын 4-т нь биеэр, 1-т нь цахимаар оролцож, зарлагдсан хурал хойшлогдож, товлосон ажилтай давхцсан тул бичгээр санал өгөх хэлбэрээр 1 удаа, Эрсдэлийн удирдлагын хорооны 4 удаагийн хуралд биечлэн оролцов. ТУЗ-ийн хурлуудад 39 асуулга, 18 санал дэвшүүлсэн.

**2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН**

1. Төрийн банкны ТУЗ-ийн 2023.08.14-ны өдрийн 10 дугаар хуралд биечлэн оролцож, 9 асуулт тавьж, 4 санал гаргасан.
2. Эрсдэлийн Хорооны 2023 оны 09-р сарын 7, 13-ны өдрүүдийн 5,6 дугаар хуралдаанд оролцож, дотоод аудитын шалгалтын мөрөөр илрүүлсэн хариуцлагагүй үйл ажиллагаанд арга хэмжээ авах саналыг дэвшүүлсэн.
3. Тогтвортой хөгжлийн тайланг гаргадаг болох санал тавьж, анх удаа уг тайланг гаргуулан олон нийтэд мэдээлсэн нь нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжилд банкнаас оруулж байгаа ажлын үр дүнг хүртээмжтэй, хяналттай болгоход ач холбогдолтой болсон.
4. Зүүнхараа суманд Ногоон дадалт малчид: мэдлэгжих аянд Малчин өрхийн санхүүгийн боловсрол сургалтыг 70 гаруй саальчин малчин эмэгтэйчүүдэд хийсэн. Зүүн хараа сумын Төрийн банкны үйл ажиллагаатай танилцан, харилцагчтай холбоотой цалингийн зээлийн эрсдэлийг бууруулахад дэмжлэг хүссэнийг судалж, зохих мэргэжлийн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн.
5. НҮБ, УБ худалдааны танхимын зохион байгуулсан Бизнес ба хүний эрх, хүний эрхийн магадлан шинжилгээ сургалтанд хамрагдан бизнесийн үйл ажиллагаанд НҮБ, Засгийн газраас тавьж байгаа зарчмуудыг хэрэгжүүлэхэд ТУЗ, Хараат бус гишүүн ямар үүрэг зорилготой хэрхэн ажиллах талаар мэдлэг мэдээллээ сайжруулж, гэрчилгээтэй болсон.
6. Санхүү банкны эмэгтэйчүүдийн чуулганд оролцон, “Хүний эрхийг дээдэлсэн нийгэм цогцлооход банк, санхүүгийн эмэгтэйчүүдийн бодит оролцоо, манлайлал” илтгэл тавьж, “Хариуцлагатай бизнес ба тогтвортой хөгжил” үндсэн хэлэлцүүлгийг удирдан, чуулганаас гаргах уриалга, тунхаг, зохион байгуулалтын ажилд оролцон, идэвх санаачлагатай ажилласан.

**2023 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН**

1. Төрийн банкны ТУЗ-ийн 2023 оны 4 дүгээр улиралд зарлагдсан 5 хурлын 3-т нь биеэр, 1-т нь цахимаар оролцож, зарлагдсан хурал хойшлогдож, товлосон ажилтай давхцсан тул бичгээр санал өгөх хэлбэрээр, Эрсдэлийн удирдлагын хорооны 2 хуралд биечлэн оролцсон. Гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулалтыг олон улсад нээлттэй зохион байгуулах ажлыг түр хойшлуулах Хувьцаа эзэмшигч Сангийн яамны саналыг ТУЗ-ийн даргаас мэдэгдсэн. Иймд Нэр дэвшүүлэх хорооны хурал хойшлогдсон.
2. ТУЗ-ийн 2023.08.14-ний өдрийн 10 дугаар хуралд 14 асуулт тодруулга, 6 санал, 2022.10.27-ны өдрийн 11 дүгээр хуралд цахимаар 6 асуулт тавьж, 2 санал, 2023.12.01-ний өдрийн 12 дугаар хуралд 4 асуулт, 3 санал, 2023.12.26-ны өдрийн 13 дугаар хуралд 6 асуулт, 3 санал, бүгд 30 асуулга тавьж, 14 санал гаргаж

оролцсон. ДАГ, ТУЗ, Засаглалын албаны 2024 оны төсөв батлуулахад тэдгээрийн хийх ажлын төлөвлөгөөний төслийг бэлдэж танилцуулсан тохиолдолд дэмжих боломжтой гэж санал өгсөн.

3. Төрийн банкны 2024-2026 оны стратеги төлөвлөгөө, 2024 оны Бизнес төлөвлөгөөнд “харилцагчдын үйлчилгээнд хүний эрхийг дээдлэх соёлыг төлөвшүүлэх, хүний эрхийн магадлан үнэлгээ хийлгүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй үйлчлэх ажлуудыг тусгуулан, Тогтвортой хөгжлийн төлөвлөгөөт ажлуудын хувьд зорилтот тоо, хувь хэмжээг тогтоосноор үнэлэх дүгнэх боломжтой болгуулж батлуулсан.
4. 2024 оны төлөвлөгөө төсөв боловсруулахад банкны бүх төрлийн эрсдэлийн түвшин үнэлгээ ямар байхаар тооцоолж байгаа, эрсдэлийн түвшинг хянаж удирдахын тулд ямар ажил, санхүүгийн хэрэгслүүдийг ашиглахаар төлөвлөж төсөвлөсөн талаар нэмэлт асуулга тодруулга тавьж, хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд шаардлага бүрэн хангасан эсэх талаархи хуулийн болон дотоод аудитын дүгнэлтийг гаргуулсан.
5. ББСБ-уудад олгосон зээлүүдийн эрсдэлийг танилцуулах үүргийг өгсөн. Өмчлөх бусад бүртгэлтэй хөрөнгийг шуурхай борлуулж, байгуулсан санг буцаах замаар ашгийг 20 гаруй тэрбумаар нэмэгдүүлэхэд анхаарах, чанаргүй муу 40 том зээлтэй холбогдуулан улс төрийн нөлөөллийг тогтоон холбогдох арга хэмжээ авах талаар санал гаргасан. Өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, брэндинг шинэчлэх талаар мэдээлэл шаардаж ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн.
6. Эрсдэл, Комплайнс, мөнгө угаахтай тэмцэх талаар 2024 онд хийх ажил, тэдгээртэй холбоотой төсөв хөрөнгийн мэдээлэл саналыг нэмж ирүүлэхийг шаардаж, материалтай танилцахад эдгээр санхүүжилт хөрөнгө оруулалтын үр дүнд эрсдэлийн түвшинг хянаж, бууруулах боломжтой гэсэн мэдээлэл авсан тул төсвийг дэмжсэн.
7. Их хэмжээний хэлцэл ТУЗ-ын хуралд танилцуулагдаагүй. Сонирхлын зөрчилтэй хэлцэл 1 удаа яаралтай журмаар оны эцсийн ажлын өдөр танилцагдсан бөгөөд бичгэн хэлбэрээр дэмжиж байгаага илэрхийлсэн.
8. Компанийн тухай хуулийн 79.3-т заасны дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүний үүргүүдийн биелэлт

<p>79.3.1.төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;</p>	<p>Үйл ажиллагааны хагас жилийн тайлангийн үр дүнг цаг алдаж ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж байгаад шүүмжлэлтэй хандаж, 3 дугаар улирлын тайланг ТУЗ-ийн хурлаар шуурхай хэлэлцүүлэхийг шаардсан.</p>
<p>79.3.2.компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;</p>	<p>Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай ажиллах төлөвлөгөөг хэлэлцэх үед хаалтын гэрээ хийдэг эсэхэд тодруулга авч, сонгон шалгаруулалтыг зохих хууль дүрмийн хүрээнд зохион байгуулж ил тод байх зарчмын хүрээнд ажиллахыг зөвлөсөн. Банк нь хувьцаат компани болсноор</p>

	СЗХ-ноос гаргасан шаардлагуудад нийцүүлэн тайлагналын хүрээ нэмэгдэж, илүү нээлттэй болсон.
79.3.3.хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.	Хувьцаа эзэмшигчдийн хурал болоогүй
79.4.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авалтын талаар санал боловсруулах	Аудитын хорооны гишүүн бус тул ийм санал боловсруулахад оролцох боломжгүй.
79.4.2.гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн зарчимд нийцүүлэн үр ашигтай зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих.	Өмнө нь шаардаж байсны дагуу Банкнаас 2023 оны Худалдан авах ажиллагааний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 15 -ны өдөр ирүүлсэн бөгөөд Аудитын хорооны дарга худалдан авалттай холбоотой Хорооноос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ТУЗ-ийн хуралд танилцуулсан

9.НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Европийн холбооны санхүүжилтээр Монголын Эмэгтэйчүүдийн Хөдөлмөрийг Дэмжих Холбооноос “Хүндээ ээлтэй хамт олон” төслийн хүрээнд 2 өдрийн сургалтанд хүний нөөцийн захирлыг оролцуулан, сайн дурын үндсэн дээр хамт суралцсан. Төслийн хүрээнд сургагч багш болоход бэлтгэгдэн, Төрийн банкны удирдах түвшний 30 ажилтанд НҮБ-гаас гаргасан Бизнес ба Хүний эрхийн зарчмууд, ХЭҮК, Засгийн газраас баталсан тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор сургалт явуулсан бөгөөд энэ нь хүний эрхийг дээдэлсэн соёлыг хөгжүүлэх, ажлын байрны дарамт, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хүндээ ээлтэй хамт олон бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулсан.

10.Хурал тус бүрт оролцсон тухай дэлгэрэнгүй тайланг Монголбанканд тухай бүр гаргаж өгсөн бөгөөд хурлын товч мэдээллийг хурал тус бүрээр ТУЗ-ийн хурлын протоколоос НБД-аар гаргуулж, хавсралтаар хүргүүлж байсан.



Тайланг гаргасан

Д. ЭНХЖАРГАЛ